



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 18



Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 103.5 мянган га-гаар буюу 19.3 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд 2021 оны 7 дугаар сарын 1-ний байдлаар 640.4 мянган га талбайд тариалалт хийснээс үр тариа 422.9 мянган га-д, техникийн ургамал 97.1 мянган га-д, таримал тэжээл 89.4 мянган га-д, төмс 19.8 мянган га-д, хүнсний ногоо 9.9 мянган га-д, бусад ургамал 1.2 мянган га-д тариалсан байна.

Хүснэгт 1. Тариалсан талбай, ургамлын төрлөөр, жил бүрийн 7 дугаар сарын 1-ний байдлаар

|                   | 2018 VII.1 | 2019 VII.1 | 2020 VII.1 | 2021 VII.1 | <u>2021 VII.1</u><br>2020 VII.1 |
|-------------------|------------|------------|------------|------------|---------------------------------|
|                   | мян.га     |            |            |            | хувь                            |
| Бүгд              | 500.4      | 518.8      | 536.8      | 640.4      | 119.3 ↑                         |
| Үр тариа          | 367.2      | 369.3      | 390.1      | 422.9      | 108.4 ↑                         |
| Буудай            | 342.7      | 343.0      | 364.5      | 389.3      | 106.8 ↑                         |
| Төмс              | 12.7       | 14.8       | 18.4       | 19.8       | 107.5 ↑                         |
| Хүнсний ногоо     | 8.5        | 8.3        | 9.6        | 9.9        | 103.5 ↑                         |
| Таримал тэжээл    | 40.9       | 41.2       | 53.9       | 89.4       | 165.9 ↑                         |
| Техникийн ургамал | 70.0       | 85.1       | 63.8       | 97.1       | 152.2 ↑                         |
| Бусад             | 1.1        | 0.3        | 1.1        | 1.2        | 113.9 ↑                         |

Нийт тариалсан талбай өмнөх оны мөн үеэс 103.5 (19.3%) мянган га-гаар өссөн байна. Ургамлын төрлөөр авч үзвэл, таримал тэжээл 35.5 (65.9%) мянган га, техникийн ургамал 33.3 (52.2%) мянган га, үр тариа 32.9 (8.4%) мянган га, төмс 1.4 (7.5%) мянган га, хүнсний ногоо 0.3 (3.5%) мянган га, бусад ургамал 0.2 (13.9%) мянган га -гаар тус тус өссөн байна.

**Ойлголт, тодорхойлолт:**

**Тариалсан талбай** гэж газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж, байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг ойлгоно.

**Тооцох аргачлал:**

Тариалсан талбай: Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац: Тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлно.

Га-гийн ургац: Талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.



Эх үүсвэр: ҮСХ, Газар тариалангийн мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархах хуваарь: 2021 оны 9 дүгээр сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын  
Статистикч Х.Энхжавхлан  
Утас : (976-51)-261565

